

## ХЯТАДЫН ШАО ЛИН ХИЙДИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН ТОЙМ

М.Гантуяа (Доктор, PhD)  
Дорноо (Магистрант, DaoRiNa - ӨМӨЗО)  
МУИС, ШУС, Философи, шашин судлалын тэнхим

**Түлхүүр үгс:** Шао Лин хийд, Сунг Шань уул (Song Shan), Буддхабадра (Buddha Bhadra), Да Мо (Da Mo), Чань бодхисатва, Хүи Кэ (Hui Ke), Хүй Нэнг (Hui Neng), Конфу, Чань Буддизм, бие хамгаалах урлаг.

**Товч утга:** Хятадын Шао Лин хийдээс Хятадын болон Дорно дахины, тухайлбал Зүүн Азийн ард түмний оюуны болон эдийн соёлд оруулсан үнэт зүйл нь хэмээвээс, даруй Энэтхэгт үүссэн Буддын соёлыг Хятад газарт, Хятад соёлд идээшүүлсэн, Буддын соёлыг Хятадаар дамжуулан Зүүн Азид дэлгэрүүлсэн, Хятадын соёлын өвөрмөц онцлогийг тусгаж Зүүн Азид дэлгэрсэн Чань Буддизм буюу Чань Бодьсадвын шашины үүсэл хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан явдал болно. Чань Бодьсадвын урсгал нь Хятадын бичгийн соёл, Бумбын шашины үзэл санааг Буддын соёлтой нийцүүлэн зохицуулсанаараа онцлог билээ. Мөн Шао Лин хийд нь шавь хуврагуудаа хүмүүжүүлэн боловсруулах өөрийн гэсэн өвөрмөц арга ухааныг бий болгосон нь Конфу-гийн бие хамгаалах урлагийг Буддын шашины боловсролтой цогц болгосонтой холбоотой. Цаг хугацаа улиран өнгөрөхийн хэрээр Буддын сургаалд суурилсан Конфу бие бялдарын боловсрол нь сүм хийдийн амар төвишин байдал, эдийн өв соёлыг хамгаалах төдийгүй төрийн хамгаалалтын нэгэн төрлийн арга болж, нийгэм-түүхийн хөгжлийн үе бүхний онцлогт тохируулж арга ухаанаа олон талаар тэлэн хөгжүүлээр иржээ. Шао Лин хийдийн Конфу эрдэм нь Буддын бясалгалд суурилсан бие бялдарын хүмүүжил олгох бүхэл бүтэн систем болж боловсорсон байна.

\* \* \* \* \*

Монгол Улс өмнө талаараа Хятад, хойд талаараа Орос улстай хил залгаж оршдогийн хувьд энэ хоёр улсын ард түмний оюуны соёл, шашин, үзэл суртлын түүхтэй танилцаж байх нь гурван орны харилцаа, хамтын ажиллагааг зохицуулахад чухал үүрэгтэй гэж үзэж энэхүү өгүүллийн хүрээнд Хятадын ард түмний шашин шүтлэгийн салшгүй хэсэг болох Шао Лин хийдийн талаар тойм өгүүлэхээр шийдлээ.

Хятадын Шао Лин хийдийн талаар монголчууд гол төлөв уран зохиол, кино жүжиг зэргээс мэдээлэл авдаг. Харин энэхүү өгүүллийн хүрээнд хятад хэл дээрхи зарим түүхэн болон судалгааны ном зохиолыг ашиглан Шао Лин хийдийн түүхийн талаар уншигчдад бодит мэдээллийг өгөхөөр зорьсон болно.

Шао Лин хийдийн талаар түүхэн тойм мэдээлэл өгөхийн тулд, юуны өмнө **Шао-Лин хийдийн үүсэл гарлын талаар** өгүүлье. Хятадын Өмнөд Умард төрийн (420-589 он) үед Бурханы шашин Хятадад хүчтэй дэлгэрч байжээ. 493 онд Умард Үй улсын (386-534 он), Сяо Вэн Ди (Xiao Wen Di) хаан төр улсаа Рин Чань (Ping Chan) хотоос Луо Янг (Luo Yang) хот руу шилжүүлжээ. 495 онд<sup>1</sup> Энэтхэгийн хувраг Буддхабадра (Buddhabhadra) торгоны замаар дамжин Луо Янг хотод ирж хаантай золгон “Арван газар”, “Олонхи бурхан нэрт машид дэлгэрсэн Их хөлгөн судар”, “Гаслангаас огоот нөгчсөн хэмээх Их хөлгөн судар” зэргийн утга агуулгыг тайлбарлаж өгсөнд хаан бишрэн шүтэж, бахдан бахархаж, бурханы шашины судар номыг орчуулах болон сургаал номыг нь дэлгэрүүлэхийн тухайд Сун Шан хайрханы

<sup>1</sup> Үй бичгийн 144-р боть (Үй Улсын түүх)

Шао Ши (Shao Shi) уулын өтгөн ойд хийд байгуулж өгөөд, уулын нэрээр нь Шао Лин хийд (Shao Ling si) хэмээн нэрлэжээ<sup>2</sup>.

Эртний Хятад хүмүүсийн ертөнцийг үзэх үзэлд Хятад улс бол тэнгэр, газрын төвд суурьшиж байгаа улс гэж үздэг. Энэхүү тэнгэр, газрын төв нь Хятадын Жэнг Жоу (Zheng Zhou) хот, Луо Янг хот, Сун Шань уулын ойр хавиар оршдог гэх домгоос үүдэн Хятадын соёл боловсрол энэ хавиар төвлөрчээ. Хятадын эртний ёс жаяг, одон орон судлал, Күнзийн сургаал, Бурханы шашин зэрэг соёл боловсролын олон урсгал чиглэлүүд энэ газарт голлон дэлгэрч, ариун дагшин ууланд мөргөж, уулын сахиусанд ном судар уншиж, тахилга явуулах зэргээр олны хөл ихтэй суурин газар болжээ<sup>3</sup>. Ийнхүү Хятад хүмүүс шихү Луо Янг хот болон Сун Шань уулаар суурьшсан нь энэ газар Хятадын оюуны соёлын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэх шалтгаан болжээ.

Луо Янг хот бол Хятадын түүхэнд хамгийн урт хугацааны турш төрийн нийслэл хот, төв газар байсан юм. Мөн түрүү үеийн төр улсууд дотроос хамгийн удаан хугацаанд хааны хот-нийслэл байсан байна. Тухайлбал, 13 хаан энэ хотыг нийслэлээ болгож, 8 хаан дагуул нийслэлээр хөгжүүлж байжээ<sup>4</sup>. Иймээс Луо Янг хот нь түүхэн дэх хамгийн чухал төр улсын нийслэл байж, эдийн засаг, соёлын гол төв, торгоны замын эхлэлт болсон юм. Эдгээр нөхцөл шалтгаанаас үүдэн хийдийн мандал хөгжил, буурал доройтолд цэргийн үйл ажиллагаа, түүхэн дайн самуун холбогдсон байна.

Умард Үй улсын үед анх хийд байгуулагдсанаас эхлэн хийдийн аливаа зардал санхүүг дараа дараагийн бүхий л үеүүдэд төрөөс хангадаг уламжлал тогтжээ. Гэвч Умард Жоу (Zhou) улсын (557-581 он) Ү Ди (Wu Di) хаан бээр 574 оны 5 сарын 17-ны өдөр зарлиг буулган, Бурханы шашин болон Бумбын шашныг таслан зогсоож, судар шүтээн зэргийг нь эвдэн сүйтгэж, шашинтан, санваартан, бумба нарыг хар болгож, хийдийн эд хөрөнгийг ноёд түшмэд нарт хувааж, сүм суварга зэргийг нь ван гүн нарт шагнаан соёрхож тараан өгчээ<sup>5</sup>. Үүнээс болж Шао Лин хийдийн лам хуврагууд ой шугуйд дутаан, аглаг далд сууж, хүний орчноос хөндийрөн, ёс заншил, дадал мөрөө нууж, салан бутарсан байна. Ү Ди хаан нас нөгчсөний хойно нэгэнт тогтсон нийгмийн суурь өөрчлөгдсөнгүй, хэвшсэн дадал зуршлыг хувиргахад амаргүй болсон ч, дараагийн Жинг Ди (Jing Di) хаан нийгмийн эмх журмыг Күнзийн сургаал болоод Бурханы шашин суртахуунаар сахин хамгаалах хэрэгтэй гэж үзсэн юм. Тэрээр 580 оны 6 сард Бурхан шашин, Бумбын шашин хоёрыг сэргээн хөгжүүлэхийг уриалж, ууланд даяанчлагч шашны санваартан, бумба нарт чин үнэн сэтгэлээр сахил санваараа баримтлан хүнд суртлын хүлээснээс чөлөөлөгдөн зам мөрдөө орж, буян номоо үйлдэж болох тухай зарлиг буулгасан байдаг.

Ийнхүү Шао Лин хийдийн лам хуврагууд сүм хийддээ буцан цуглаж, сүмийн нэр нь Жи Ху (Zhi Hu) сүм хэмээх нэрээр солигджээ. Учир нь, тэр үед бурханы шашин ихэд түгэн дэлгэрч, Хойд Зү улсын төрийн удирдагч нар ч өөрсдөө ч бурханы шашинд гүнзгий орсон байдаг. Тоо бүртгэлээр бол Хойд Зү улсын хатны ойр хавийн арван хүн бурханы шашинд итгэл бишрэл явуулсан гэдэг. Тэдгээрийн зургаа нь чавганц болсон, тухайлбал, Үди хааны Жин Ли (Jin Li) хатан, Шуан Ди (Xuan Di) хааны Жу (Zhu) хатан, Жин Ди хааны төрсөн эх нь болон Шуан Ди хааны Чэнь (Chen) хатан, Юань (Yuan) хатан, Вэй Хоу (Wei Hou) хатан зэрэг хатад ар араасаа залган хааны ордноос гарч сүмд чавганц болон суух явдал их болжээ<sup>6</sup>.

Жинди хааны үед буюу 579-586 онд Шао Лин хийдэд анх сэргээсэн бурханы хөрөг шүтээн бол Тэнгэрийн бурханы хөрөг байсан юм. Үүнд хоёр нийслэл, Чанг Ань (Chang

<sup>2</sup> Шао-Лин хийд. Шанхай номын хэвлэл. 1982 он. 2 дахь тал

<sup>3</sup> Шао-Лин хийдийн түүх, шашин болон эдлэм боловсрол. Шашин суртахуун, соёлын хэвлэлийн хороо. 2016. 4 дэх тал.

<sup>4</sup> Шиа Улс мээ 2070-1600 он, Shang улс мээ 1600-1046 он, Zhou улс мээ 1046-256 он, Dong han улс 25-220 он, Вэй Улс 386-534 он, Сий улс 581-618 он, Танг Улс 618-907 он, Ву Жоу Улс 690-701 он, Хоу Лианг Улс 907-923 он, Хоу Танг Улс 923-936 он, Хоу Жинь Улс 936-947 он.

<sup>5</sup> Зөө бичгийн 5 дугаар боть. Үү Ди-ийн түүх. Тан улсын үеийн үлдээгдэл бичиг.

<sup>6</sup> Зөө бичгийн 9 дүгээр боть. Хатдын сул намтар.

Ап) болон Луо Янг хотод тус бүрийм хөрөг шүтээн нэг нэг байж, хаан бээр чавганц болсон эхийн болон хатдын ач тусыг санаж мөрөөдөн болж Зихү сүм хэмээн нэрлэжээ.

Ийнхүү Шао Лин хийд сэргэн хөгжсөн эхэн үед Жин Ди хаан 120 шалгарсан сүсэгтэн хийгээд санваартныг Шао Лин хийдэд оруулсан юм.

581-600 онд Умар Зө улсын тэргүүн сайд Янг Жиан (Yang Jian) бээр Сүй (Sui) улсыг байгуулж, Вэн Ди (Wen Di) хаан цол өргөмжилсөн байна. Хаан сууриа хамгаалахын үүднээс төр болон ардын дунд Бурханы шашиныг ихэд дэлгэрүүлэн, Шао Лин хийдэд 100 Шан (666 га) тариа будааны хотгор газар болон нэг суурь усан тээрмийн барилга байгууламжыг онцгой анхаарал хандулан соёрхон хүртээжээ<sup>7</sup>.

Үүнээс хойш 1000-аад жилийн туршид Шао Лин хийд нь олон үеийн төр улсын өөрчлөлт солигдолыг дагалдан зарим үед мандан хөгжиж, зарим үед бас бууран доройтож ч байжээ. Удаа дараагийн ардын бослого хөдөлгөөнөөр хуучин ноёдын төр захиргааг унагаахад газрын эзний эрх авсан Шао Лин хийд ч мөн хүнд цохилтонд нэрвэгддэг байв. Шинэ төр байгуулагдаж, үзэл санааны ноёрхолыг чангатган эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага гарах бүрийд Шао Лин хийд энэ хэрэгцээг даган мандан дэгжиж байв.

Сүй Янг Ди (Sui Yang Di) хаан сууж байсан 605-617 оны сүүлчээр ард түмэн биеийн хар хүчний хүнд хөдөлмөр болон цэргийн албаны хатуу зовлонг дааж тэсвэрлэхээ больж, газар сайгүй цэрэг хөдөлгөж, бослого гарган, төрийг эсэргүүцсэн тэмцэл өрнүүлж эхэлжээ. Ялангуяа Хэ Нань (He Nan) мужийг эзэлсэн Ва Ганг (Wa Gang) цэрэг арми бол эсэргүүцэл хөдөлгөөний гол хүч болж байв. Лө Янг хотын орчмын ядуу зүдүү тариачин ард хойно хойноосоо цуурайлан дагаж бослого гарган, Сүй улсын төр засаг болон газрын эздүүдийг эсэргүүцэн тэмцэх үйл явцын дунд хотын ойр орчмын арвин элбэг газар тариаланг төрийн хамжлагаар эзэмшиж байсан Шао Лин хийдэд ч хүнд цохилт үзүүлэн, хулгай дээрэмчид хийдийг гэнэдүүлэн булаан дайрч, сүмд гал түймэр тавьж, олон суварга, гэр байшин, дуган харш нугуудыг халдан сөнөөсөн юм. Энэ удаагийн түймэр самуун нь Шао Лин хийдийн түүхэн дэх анх удаагийн түймэр байсан юм. Үүнээс хойш сүмийнхээ амар тайван байдал болон эд хөрөнгөө хамгаалах үүднээс хийдийн хуврагууд гар зодоон болон зэвсэгт тэмцэлд биесээ бэлтгэж, цэргийн зохион байгуулалтанд орж, хулгай дээрэм болон засгийн цэрэгтэй тулалдан байлдаж, Шао Лин хийдийн эрдэм боловсролыг Кунг фу<sup>8</sup>-гийн биеийн тулаан, зэвсэгт хүчинтэй хавсарган эзэмшиж эхэлсэн байна<sup>9</sup>.

**Шаолин хийдийн хөгжлийн дараагийн нэгдүгээр үе нь** Тан улсын үед хамаарна. 619 онд Умар Сүй Улсын жанжин Ван Ши Чунг (Wang Shi Chong) өөрийгөө Луо Янг хотод хаан өргөмжлөн улсын цолоо Зэн (Zheng) гэж нэрлэсэн байдаг. Тэрээр Тан улсын Ли Ши Мин Тай Зун (Li Shi Min Tai Zong) хаантай байлдахад Шао Лин хийдийн хуврагууд Тан улсад бүслэлтээс гарахад нь дэмжлэг үзүүлж гавъяа байгуулжээ. Тайзун хаан шийдвэрлэх хүчин болж зүтгэсэн үзүүлсэн 13 хуврагт шан хүртээжээ. Тухайлбал, Тан Зун (Tan Zong) хэмээх хуврагийг өрлөг жанжинаар шагнаж, ноён зэрэг хүртэх дургүй үлдсэн 12 хувраг тус бүр орхимж хүртээж, Шао Лин хийдэд 40 Шан (266 га) тариалангийн газар шагнан, усан шуудуу шагнажээ. Мөн Тан улсын төрийн удирдагчдын хүндэтгэлийг ихэд хүлээсэн байна. Тус байлдааны ялалтаас Шао Лин хийд ч төрөөс их хэмжээний дэмжлэгийг хүртэж, нэр алдар нь дотоод гадаадад дуурсагдах Бурханы их сүм хийд болсон төдийгүй “Дэлхий дахины тэргүүн сүм” гэдэг цол алдрыг хүртжээ<sup>10</sup>. Түүнчлэн тус ялалтаас Шао Лин хийд нь эрэлхэг баатарлаг хийд гэдгээрээ улс орондоо нэр алдаршиж, сүмийн лам хуврагуудад Кунг фугийн эрдэм боловсролыг эзэмшүүлэн хөгжүүлэх уламжлал тогтоож, тэр нь үеийн үед уламжилсаар ирсэн юм. Үүнээс хойш Шао Лин хийдийн эрдэм боловсрол нь төрийн

<sup>7</sup> Сүй бичгийн 2 дугаар боть. Го үндэслэгчийн тэмдэглэл.

<sup>8</sup> Конфу гэдэг нь биеийн тамирын боловсрол гэсэн утгатай гэсэн хятад үг

<sup>9</sup> Шао Лин хийд. Шанхай номын хэвлэл. 1982. Х.5

<sup>10</sup> Tang Pei Sui. Шао Лин хийд дэх чулуун хөшөөний бичээс.

хэмжээнд үйлчлэх эрх олсон юм.

Тан улсын Гоо Зунг (Gao Zong) болон Ү Хоу (Wu Hou) хаадын төр суухын үест Луо Янг хот нь төр засгийн төв газар болсон билээ. Сун Шан уулыг нийслэлийн ойролцоо байгаа болохоор нь “Богд хайрхан” хэмээн нэрлэж, Шао Лин хийдийг Чань буддизмын хийд болохоор нь хаад ноёд тэнд цаг үргэлж морилон саатдаг хишиг газар болгосон юм. Тэрчлэн Ү Хоу хаан Тан улсын цолыг Жоу (Zhou) хэмээн нэрлэж, бурханы шашиныг төрөөс онцгой эрхэмлэн чухалчилах болжээ. Шао Лин хийд хааны ээжийн дурсгалд зориулан арван давхар Бурханы суварга цогцлоон байгуулсанд талархаж Шао Лин хийдийг магтан шүлэглэсэн соёрхолыг чулуун хөшөөнд сийлэн үлдээсэн нь одоо хэр буй<sup>11</sup>.

Тан сүн улсын үед Шао Лин хийдийн тариалангийн газар нь 14000 мүү (932 га), сүмийн барилгын суурь нь 540 мүү (36 га)-д хүрч, 5418 өрөө тасалгаа бүхий асар том барилга байгууламжтай болжээ. 984 оны үеэс гэхэд тэдгээрт 2000 гаруй хувраг санваартан сууж, 9500 бум судар номтой болсон байв.

Сун улсын үед Хятадад байгалийн шинжлэх ухаан ихэд хөгжин дэлгэрсэн бөгөөд Күнзийн сургаал, Бурханы шашинтай хамсран тэрхүү шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн үзэл санаанд нөлөөлсөн нь эргээд Хятадын Чань Буддизмын хөгжилд нэгэн шинэ үеийг эхлүүлсэн нь *“Тэрэл саируулсан хоёрдугаар үе”* хэмээх хөгжлийн нэгэн шинэ үе болсон юм. Энэ үе нь их Юань улсын үед хамаарна. Хубилай хаан суусны дараа төрсөн дүү Аригбөх тэргүүтэй удмын ноёдын хатуу эсэргүүцэлтэй тулгарсан байна. Иймд, эзэлсэн улс орноо хэрхэн захирах, ноёдын эсэргүүцлийг хэрхэн дарж нэгтгэх тухайд Хубилай хаан оюун санаагаа чиглүүлсэн юм. “Улс иргэнийг эзлэхэд, урьдаар түүний биеийг эзэлж дараа нь түүний санааг олох хэрэгтэй. Санаа сэтгэлийг нь олвоос, бие нь аяндаа сэтгэлээ дагах ажгуу” гэсэн эзэн Богд Чингис хааны билиг сургаал түүнд маш их ухаарлыг өгчээ.

Хүмүүний оюун бодлыг эзэмдэхэд сэтгэлийг нь бишрүүлэн татах хэрэгтэй гэж үздэг Хубилай хааны хувьд гүн нарийн үзэл, учир шалтгааны нягт ухаарлыг номлодог Буддын шашны сургаал нь хүмүүнийг бишрүүлэн татах увьдсаараа бусад аль ч шашин сургаалтай адилтгагшгүй болох нь танигдсан юм.

Хубилай хаанаас өмнө Годан ноён Тангадыг төвшитгөхөөр Тангадын нутгаар өнгөрөх үедээ Пагва лам Лодойжалцангай уулзан, түүний эрдмийг шүтэж, дэргэдээ үлдээсэн бөгөөд түүнээс авшиг авчээ Энэ үйл явдлын үзэл санааны нөлөөгөөр 1260 онд Хубилай их хааны сууринд гармагц Буддын шашныг төрийн шашнаа болгож, Пагва ламыг улсын багшаар залж, төр-шашны хос ёсны харьцааг хуульчлан тогтоож, Буддын шашны нийгмийн үүргийг хэрэгжүүлэн, улс үндэстэний хөгжил давшил ба нийгмийн амар амгалан байдлыг тогтооход бурханы шашны нөлөөг ашигласан юм.

Үүнээс гадна, 1258 онд Хубилай хааны зарлигаар Шанг Ду (Shang Du) хотод Буддын шашинтан болон Бумбын сургалтаны хооронд номын мэтгэлцээн болоход Хубилай хааны урилгаар Шао Лин хийдийн Фү Ёу (Fu Yu) багш (1203-1275) оролцож, Буддын шашинтнууд ялалт байгуулсан байдаг. Энэхүү номын мэтгэлцээн Хубилай хаанд маш их сэтгэгдэл төрүүлсэн гэдэг. Тиймээс ч, Хубилай хаан зарлиг буулган Бумбын сургаалын 40 гаруй ном судрыг шатаан устгаж, улсын 237 бумбын сүм хийдийг бурханы шашинд шилжүүлсэн байна. Хубилай хаан мөн зарлиг буулган Фү Ёу багшийг Шао Лин хийдийн хамбаар өргөмжлөхийн хамт Сүнг Шань хайрханы орчимын бүх сүм хийдийг ерөнхийлөн захирах эрхийг олгосон юм. 1312 онд улсын түмний ноён өргөмжлөн соёрхсон нь Шао Лин хийдийн түүхэнд түмний ноён болсон цорын ганц хувраг байлаа. Фү Ёу багш Шао Лин хийдийн хамба суух хугацаанд хийд маш ихээр хөгжин мандаж “Хонхон асар”, “Хэнгэрэгт асар” зэргийг байгуулан, гудамж талбай, барилга байшингуудыг хүртэл сэлбэн засаж, тэр үеэс хотын өнгө гэрэлтэн гялалзаж,

<sup>11</sup> Шао Лин хийдийн матерөөлийн бүтцийн Үргэлжлэл - *Wu Hu*, *Liu Zhi Xue* найруулав. *Si An* шин ухаа хэвлэлийн хороо хэвлэв. 1984 он. X59.

шинэ төрхийг олсон юм<sup>12</sup>.

Үүнээс хойш Шао Лин хийдийн дараагийн улам цэцэглэн бадарч хөгжсөн гуравдугаар үе бол Мин улсын (1368-1644) үе болно. Шао Лин хийдэд бурханы хөрөг шүтээн, даяанд суух орон байр зэргийг сэлбэн засч, сүмд хамгийн том дуган “Мянган бурханы дуган”-г байгуулж<sup>13</sup>, Сүн улсын үед (420-479) байгуулсан “Анхлан үндэслэгчийн их дуган”-г дахин сэргээн босгожээ. 1582 онд хааны эх нь Шао Лин хийдэд уран нарийн хийц бүхий сийлбэртэй 637 боть бурханы судар номыг тусгайлан соёрхож хайрласан юм. Мин улсын хааны хөвгүүдээс урьд хожид найман хүмүүн Шао Лин хийдэд лам хувраг болсон байдаг<sup>14</sup>.

Чин улсын Энх-Амгалан хааны үесийг (1662-1723 ) улс төрийн аян дайн, самуун мөргөлдөөн төвшин тогтсон нийгмийн амьдралын тайван үе гэдэг. Энэ үед Күнзийн сургаалыг бишрэн, бумбын сургаалыг чухалчлан, байгалийн шинжлэх ухааныг хөгжүүлж, Бурханы шашныг хүндэтгэн дээдэлж, сүм хийдийг дэлгэрүүлэн байгуулсан байна<sup>15</sup>.

Энх-Амгалан хаан суусан хөх бар жилд баруун Луо (Luo) -гийн харьяат Ши Лү Фан (Xi Lu Fan)<sup>16</sup> улсын төрийн зүтгэлтнүүд урван тэрсэлж бослого тэмцэл гаргахад Шао Лин хийдийн хуврагууд сөргөлдөн байлдаж ялалт байгуулсан тул хаан бээр тэднийг “түмний ноён”-д өргөмжлөн, түмэн лан алт соёрхжээ. Энэ үед Шао Лин хийд улам хөгжин бадарч, эд хөрөнгө элбэг дэлбэг, хаан ноёдын хайрласан ховор эрдэнэс дүүрэн болохуйд ховдог шунахай зальхай түшмэд нарын хомхой сэтгэл, атаа шуналыг хөдөлгөж Шао Лин хийдийнхэнд элдэв ид шидийн арга увдис заан сургаж, сэтгэлийг нь урвуулах зорилго өвөрлөн, тэднийг хааны эсрэг тэмцэл урвалт гаргаж байна хэмээн худал гүтгэлэг сэрдлийн үгсийг хааны сонорт хүргэн мэдээлсэн учраас хаан өөрийн байр сууриа хамгаалах үүднээс 3000 цэрэг хөдөлгөн “зул асаах” нэрээр сүмд гал тавьжээ. Ийнхүү Шао Лин хийдийн түүхэн дэх хоёр дахь их түймар гарсан юм<sup>17</sup>.

Чин улсын Найралт Төв хааны үе, 1735 онд Шао Лин хийдийн түүхэн дэх хамгийн их сэргээн засвар хийгдсэн байдаг. Найралт Төв хаан өөрийн биеээр Шао Лин хийдийн бүх барилга байгууламжуудыг шинээр сэргээн босгох зураг төслийг хянан тогтоож, Хэ Нан мужийн сүм хийдийн барилга байгуулалтыг хариуцсан захирагч сайдыг онцгойлон энэ үйл хэргийг гүйцэтгүүлэхээр тохоон томилж, сүм хийдийг урьд байсан тэр их хэмжээ, талбайгаар нь сэргээн босгожээ. Тэрчлэн Хэ Нань муж, Нан Яанг (Nan Yang) хотын засаг захиргаа, Луо Янг, Дэнг Фэнг, Гүнг Сиэн, Юунг Нинг (Luo Yang, Deng Feng, Gong Xian, Yong Ning) зэрэг хотуудаас ноёд түшмэдүүдийг сонгон шалгаруулалтаар энэ үйл хэрэгт тохоон томилж Шао Лин хийдийн түүхэнд хамгийн өргөн хүрээний сэргээн засварлалтын ажлыг гүйцэлдүүлжээ. Тус сүмийн сэргээн байгуулалтанд зориулан Найралт төв хаан арван хоёр жилийн турш усан замаар барилгын материалыг зөөвөрлөн ирүүлсэн ба хааны болон Хэ Нан мужийн хадгаламжинд байсан албан зоосыг бүгдийг зарцуулснаас гадна хийдийн ойр орчмын уулын модыг баргийг нь огтлон дуусгасан гэх мэдээ байна. Чингэхдээ хийдийн ойр орчим байсан жижиг сүмүүдийг нурааж, Шао Лин хийдийн хоёр талаар дацангийн шинэ барилгуудыг барьж, тэдгээрт хол ойр байсан бүх хувраг санваартнуудыг ирүүлэн суулгажээ<sup>18</sup>.

Чин улсын үед (1616-1912) Шао Лин хийдийн үндэслэгчдийн байгуулсан хийд дуганыг онцгойлон анхаардаг байсан юм.

Тэнгэр тэтгэгч хаан өөрийн гарын үсэг бүхий өргөмжлөл соёрхсон нь одоо болтол

<sup>12</sup> Шао Лин гийдийн матерөөлийн бүтцийн Үргэлжлэл - *Wu Hu* , *Liu Zhi Xue* найруулав .*Si An* шин ухаа хэвлэлийн хороо хэвлэв .1984 он.Х59 .

<sup>13</sup> шао лин гийдийн чулуун хөшөөгийн үлдэгдэл дээрх бичмэлүүд

<sup>14</sup> Сун-г ярьсан нь *Jing Ri Zhen* найруулав . Чин улс 1662-1722 оноогийн үлдэгдэл бүтээлийн 26 боть

<sup>15</sup> шао лин гийдийн чулуун хөшөөгийн үлдэгдэл дээрх бичмэлүүд

<sup>16</sup> Xi Lu Fan нь одоогийн Хятадын Si Chuan мужийн газар нутаг дээр байсан улс

<sup>17</sup> Шао Лин гийдийн матерөөлийн бүтэц *Wu Hu* , *Liu Zhi Xue* найруулав .*Si An* шин ухаа хэвлэлийн хороо хэвлэв .1982 он.Х138

<sup>18</sup> Шао Лин хийд шанхай номын хэвлэлийн хороо хэвлэв .1982 он.Х.8

Шао Лин хийдийн уулан дахь Шань Мэнь (Shan Men) дуганы үүдэнд байсаар байна. Мөн Баатарга явагчийн харшид Энх-Амгалан хааны гарын үсэг бүхий бичээс (эрдэнийн мод, анхилам лянхуа) одоо болтол хадгалагдсаар байгаа<sup>19</sup>.

Гэвч дундад иргэн улсын үед хувьсгалт нам болон умардын засгийн ордны самуун байлдаанаас болж Шао Лин хийд бага багаар доройтож эхэлсэн байдаг. Дундад иргэн улсын үед (1912-1949) Шао Лин хийдийн их хамба Хэнг Линь (Heng Lin) нь 1912 онд Дэнг Фэнг (Deng Feng) сүмийн холбооны хуралд сууж, Шао Лин хийдийн амар тайван байдлыг хамгаалах хороон дараагаар сонгогдож, буу зэвсэг худалдан авч, амар тайван байдлыг хамгаалах хороог зохион байгуулж, байлдааны мэргэжлийн сургалт явуулж, тухайн газар нутагт эмх журам тогтооход гол үүрэг гүйцэтгэж байжээ. 1920 онд Хэнг Линг хамба бээр амар амгаланг тогтоох хороогоо удирдан дээрэмчидтэй удаа дараа тэмцэл тулаан хийж, хийдийн ойр орчмын арваад тосгоныхны амар тайван байдлыг сахин хамгаалж байв. Гэвч 1928 оны 3 сарын 15-нд цэргийн эрхтэн Ши Сан Ёу (Shi San You) нь Шао Лин хийдийн зүүн баруун хоёр талаас бүслэн довтолж, урт их буугаар хүчлэн дэлбэлж, гал нээснээр Шао Лин хийд бүхэлдээ шатаж, хувраг санваартнууд нь галд нэрвэгдэн, үлдсэн цөөн хэсэг нь бутран дутаасан ба, түймэр нь дөчөөд өдрийн турш шатаж, үе уламжилж ирсэн алдарт сүмийг үнсэн товрого болгожээ. 5480 боть ховор нандин судар ном, сүмийн бэлгэдэл шүтээн, нударган эрдмийн цадиг зэрэг нь цөм галд өртөж, Тэнгэрийн хааны сүрлэг дуган, номын танхим болон Хонхны асар зэрэг олон сайхан чухал барилга байгууламжууд сүйдэн, Шао Лин хийд балгас болон хувирчээ. Ийнхүү Шао Лин хийд хувьсгалт нам болон умардын засгийн ордны үймээн самууны хөлд чирэгдэж, хэдийгээр Фань Юнг Сиу (Fan Yong Xiu) -гийн талынхан тэдэнд хүч хавсарсан боловч мөн л ялагдал хүлээсэн юм. Фань Юнг Сиу бол бага балчраасаа Шао Лин хийдэд Кунгфу эрдэм боловсрол эзэмшсэн хүн бөгөөд самуун байлдааны үеэр Шао Лин хийдийн газар тариалан болон эд хөрөнгийг хамгаалахын төлөө эцсээ хүртэл тэмцсэн нэгэн билээ. Дээр дурдсан Ши Сан Ёу -гийн их цэрэг Шао Лин хийд рүү довтолсон довтолгооноос Шао Лин хийд түүхэндээ ийнхүү гурав дахь их түймэрт өртөж, асар их хэмжээний сүйрэлд нэрвэгдсэн байна<sup>20</sup>.

Үүний дараа БНХАУ-ын соёлын хувьсгалын үеэр Шао Лин хийдийн хувраг санваартан нар албадан шахалтаар хар хүмүүн болж, бурханы шүтээн хөргүүд сүйтгэгдэн, сүмийн эд хөрөнгө устсан юм.

Харин 1951 онд Дэнг Фэнг ардын засгаас хөрөнгө зоос гарган Шао Лин хийдийн мянган бурханы дуганыг сэлбэн зассан нь шинэ Хятад ард улс байгуулагдсанаас хойшхи анхны сэргээн засалт байв. 1963 оны 6 сарын 20-нд түүхийн дурсгалт зүйлсийг хамгаалах зохион байгуулалттай ажиллагаанд тус хийд хамрагдсан. 1973 онд Хэ Нан муж засаг болон Кай Фэнг (Kai Feng) нутгийн захиргаа хөрөнгө бэл оруулан, Шао Лин хийдийг сэлбэн засах ажиллагааг удирдах бүлгэм байгуулж, шинэ Хятад ард улс байгуулагдсанаас хойшхи анхны их хэмжээний сэргээн засалт, барилгын ажлыг гүйцэтгэжээ.

1978 онд Хэ Нань мужийн цэргийн хороо, дотоодыг хамгаалах товчоо, ардын засгийн гадаад явдлын албаны хамтарсан албан бичиг гаргаж, Сун Шан болон Шао Лин хийд зэрэг үзэсгэлэнт газар нутаг, хийд орныг гадаад дотоодын жуулчдад нээлттэй байлгахар зарлал нийтэлжээ. 1983 онд улсын дотоод хэргийн хорооноос Шао Лин хийдийг Бурханы шашны сүм хийд болгосон. 1996 оны 12 сард Шао Лин хийдийн суварга болон анхлан үндэслэгчийн сүм дуган хоёрыг түүхийн дурсгалт зүйлийн улсын хамгаалалтанд оруулж, 1997 онд Шао Лин хийдийн аж ахуйг хөгжүүлэх ХХК байгуулагдсан байна.

2001 оноос эхлэн Хэ Нань муж, Кунг И Ци (Kong Yi Ci) сүм, Инг Янг Дунг Лин (Ying

<sup>19</sup> Шао Лин хийдийн материалын бүтцийн Үргэлжлэл - *Wu Hu ,Liu Zhi Xue* найруулав .*Si An* шин ухаа хэвлэлийн хороо хэвлэв .1984 он.Х.47

<sup>20</sup> Шао Лин хийдийн материалын бүтэц *Wu Hu ,Liu Zhi Xue* найруулав .*Si An* шинжлэх ухаан хэвлэлийн хороо хэвлэв .1982 он.Х.141

Yang Dong Lin) сүм, Син Ми Чао Хуа (Xin Mi Chao Hua) сүм, Да Лиэн Юнг Чинг (Da Lian Yong Qing) сүм зэрэг газар газрын сүмүүд дараалан Шао Лин хийдийн харьяанд орж, 2006 оны 3 сар гэхэд Шао Лин хийд нэгэнт 17 харьяа сүмтэй болоод байна<sup>21</sup>. 2006 оны 3 сар 22-ны өдөр Пү Жин (Pu Jing) бээр Шао Лин хийдэд бараалхаж, Кунфугийн тоглолтыг сонирхон үзсэн нь Шао Лин хийдийн түүхэн дэх анхны гадаадын сурвалжит зочин байлаа. 2009 онд Фэнг Инг Синг (Feng Ying Xing) ХХК-г байгуулж, Хятадын засгийн газраас анх удаа Шао Лин хийдийг гадаад улсад танилцуулах соёлын төвийн ерөнхий захиргааг үүсгэн, 2010 оны 8 сард 34 дэх удаагийн хурал дээр хянан батламжийг авч, Шао Лин хийд дэлхийн хэмжээний түүхэн дурсгалт хийдээр батламжлагдсан юм. 2013 оны 5 сард улсын дотоод хэргийн хорооноос Шао Лин хийдийн түүхэн барилгыг долдугаар удаагийн улсын тооллогод албан ёсоор бүртгэж, түүхийн дурсгалт зүйлсийн хамгаалалтанд оруулсан юм.

Шао Лин хийдээс ачлалт мэргэдийн хөшөө байгуулах ёслолын үеэр Шао Лин хийдийг Хятад ард улсын ахмад настайчуудыг хүндэтгэх, нялхсыг хайрлах, эх оронч үзлээр сурган хүмүүжлүүлэх төв газар болгосон. 2015 оны 2 сарын 23-ны өдөр хийдийн хамба Ши Юнг Син (Shi Yong Xin) бээр Шоор Хавер, Нью Сауф Уайльс, Австраль зэрэг газраас 3,238,000.00 долларын өртөг бүхий газар худалдан авч Европ тивд Шао Лин хийд байгуулах ажлыг эхлүүлээд байна<sup>22</sup>.

Шао Лин хийд нь анх байгуулагдсан цагаасаа л Буддхабадрагийн “Арван газар” зэргийн бурханы гүн номлол сургаалаар умард Үй улсын хааны хүндэтгэл бишрэлийг олж, эдүгээг хүртэл 1500 гаруй жилийн түүхийн турш төр засаг солигдох бүрт нийгэм-түүхийн нөхцөл шалтгааныг дагалдан өөрчлөгдөж, нэг үе хөгжин мандаж, нэг үе бууран доройтож, гурван удаагийн их түймэрт өртөж, үеийн үедээ Да Мо (Da Mo) -гийн Чань Буддизмын сургаалыг уламжлан, мөн Кунфу эрдэм боловсролыг хавсран хөгжүүлж, Хятад дахь Шао Лин хийдийн өвөрмөц онцлог бүхий цогц эрдэм боловсролыг далгарүүлж иржээ.

Шао Лин хийд нь Хятад оронд янз бүрийн төр улс солигдох явцад Бурханы шашныг Хятадын нийгмийн хөгжлийн өвөрмөц онцлог үе бүхэнд тохируулан хөгжүүлсээр хятадын оюуны соёлын нэгэн бэлгэ тэмдэг болж, шинэ Хятад ард улсын үеийн Хэ Нань мужийн түүхийн дурсгалт зүйлсийн хамгаалалтанд бүртгэгдэж, хөгжлийнхөө нэгэн шинэ алхамд орсноос гадна бурханы сургаал номлолыг дэлгэрүүлэх, Шао Лин хийдийг дэлхийн тавцанд гаргахад анхаарлаа хандуулж байна.

## НОМ ЗҮЙ

1. 景日珍：《说嵩》，第26部，清康熙间1662-1722年历史北京出版，1722年。
2. 令狐德棻：《周书》，第5，9，47部，唐贞观十年长安出版，636年。
3. 唐裴淮：《少林寺碑》，河南：少林寺石碑，617年。
4. 魏波：《魏书》，第144部，北魏550-577年历史洛阳出版，577年。
5. 魏征：《隋书》，第2部，唐朝621年历史长安出版，629年。
6. 无谷，刘志学：《少林寺资料集》，西安新华出版社，1982年。
7. 无谷，刘志学：《少林寺资料集续集》，西安新华出版社，1984年。
8. 夏维列：《少林寺历史宗教与武术》，宗教文化出版社，2016年。
9. 赵宝骏：《少林寺》，上海：上海人民出版社，1982年。
10. <http://www.shaolin.org.cn>

<sup>21</sup> Агваан-Иисамбуу

<sup>22</sup> [www.shaolins.org.cn](http://www.shaolins.org.cn)